



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Х ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 19:00 цагт Төрийн ордонд ⁷⁷⁵хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Халдварт цар тахлын тархалтын нөхцөл байдал, цар тахлын талаар Улсын онцгой комиссын дэргэдэх эрдэмтэн судлаачдын санал;

ХӨСҮТ-ийн захирал Л.Баттөр,

2. Худалдаа үйлчилгээний байгууллагуудад хийгдэж буй хяналт, шалгалтын талаарх мэдээлэл;

*Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн
Т.Гантулга,*

3. Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх танилцуулга мэдээлэл;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд
Г.Сайханбаяр, Улсын онцгой комиссын гишүүд,
Агентлагийн дарга нарт.

1.1 Улаанбаатар хотын төвд халдварын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг халдварын эсрэг хамтдаа уриан дор нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, объектод тавих хяналт, шалгалтыг батлагдсан тушаал удирдамжийн дагуу шуурхай зохион байгуулж халдварын тархалтыг бууруулах арга хэмжээ авах;

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой
комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Улаанбаатар хотоос орон нутагт зорчих хөдөлгөөнийг зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаан (эрүүл мэнд, буяны ажил)-тай иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэр (хүнс, шатахуун, өвс, тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл, уул уурхай) тээвэрчдийг 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд тухайн аймгийн Онцгой комиссын шийдвэр, халдвар бүртгэгдсэн газраас PCR шинжилгээний хариуг үндэслэн халдвар хамгааллын дэглэмийг хатуу мөрдүүлэн нэвтрүүлэх, орон нутаг руу чиглэсэн бусад хөдөлгөөнийг хориглох;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүд,

Аймаг, нийслэлийн засаг дарга нарт:

3.1. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалт өндөр байгаатай холбогдуулан халдвар илэрсэн Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Орхон, Төв, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Увс аймгуудыг халдварын тархалтын Улаан түвшинд 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд шилжүүлэх, нийслэлд халдварын тархалтын Улбар шар түвшинд шилжсэн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгах;

3.2. Улаанбаатар хотоос хөдөө орон нутаг руу зайлшгүй шалтгаанаар зорчиж буй иргэдийг тухайн орон нутгийн Онцгой комиссын шийдвэрээр 5-7 хоног заавал тусгаарлах;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой
комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын
гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Өмнөговь, Дорноговь аймгийн засаг дарга нарт:

4.1. Өмнөговь, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт зорчих иргэдийн хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 14 хоногийн хугацаагаар зогсоох /буяны ажил, хүнс, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгсэл болон өвс, малын тэжээлийн тээвэрлэлтийг зөвхөн Улсын онцгой комиссын Шуурхай штабаас олгосон зөвшөөрлийг

4.2. Өмнөговь, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрт орших хилийн бүс орчмын сумдын иргэдийг коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтад хамруулах ажлыг 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс эхлүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Тав. Улсын онцгой комиссын гишүүд,
Агентлагийн дарга нарт:

5.1. Улсын онц чухал болон нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий объект, байгууллагад халдвар хамгааллын хатуу дэглэм тогтоож ногоон бүс үүсгэн хэрэгжүүлэх;

Зургаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл
мэдээлэлтэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын
гишүүн Ц.Ганзориг,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд
нарт:

6.1. Халдварын тохиолдол эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэд, олон нийтэд мэдээллийн нэг сувгаар анхааруулга, зөвлөмж, сэрэмжлүүлгийг шуурхай мэдээлэх;

Долоо. Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазарт:

7.1. Томоохон зах худалдааны төв, үйлдвэр үйлчилгээний газрын удирдлага болон төлөөлөгчтэй уулзаж, ажиллах цагийн хуваарьт зохицуулалт хийх ажлыг зохион байгуулах;

ДАРГА  С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА  Ж.АМГАЛАН